



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
С.ЯГААНЦЭЦЭГ ТАНАА

2019.03.25 № 61

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу "Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагч"-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

"Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагч"-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагч"-ийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Ягаанцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу "Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.15-наас 2019.03.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар"-ын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг "Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газар"-т 2019.03.15-ны өдрийн №1/214 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн ба 10 хоногоор хугацаа хоцроосон байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Шивээговь сумын Засаг дарга" нь "Хууль тогтоомж, төр засгийн бусад шийдвэр болон Засаг даргын бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, мэргэшлийн зөвлөгөө, бүх талын үнэн зөв, бодит мэдээллээр хангах, Засаг даргаас үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцлийг баталгаатай бүрдүүлэх замаар иргэдэд тэдний эрэлт хэрэгцээ, шаардлага, сэтгэлд нийцсэн, үр нөлөөтэй, үр ашигтай төрийн үйлчилгээ үзүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

"Шивээговь сумын Засаг дарга"-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

"Шивээговь сумын Засаг дарга"-ын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд эрх зүйн орчинд өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдаж, 2 байгууллагад аудитад хамрагдаагүй байна.

Төрийн аудитын байгууллагаас "Шивээговь сумын Засаг дарга"-ын эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	1			
2	ЗГТС		1			
3	ОНТС		1			2
	Дүн	5	3			2

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Сангийн яамны е-тайлан" онлайн програм хангамж ашигладаг байна.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн тайланг хянаж хүлээн авдаггүй, тоон мэдээллүүд зөрүүтэй, журам, зааврын дагуу үнэн зөв нэгтгээгүй, тайлангуудын хоорондын уялдаа алдагдсан зэрэг нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад "Шивээговь сумын Засаг дарга"-ын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн" жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр "Нийт зардал"-ын 1 хувиар сонгов.

"Нийт зардал"-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн зардлаас тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны нийт зардал 3,072,718.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 30,727.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 160,668.9 мянга, Засгийн газрын тусгай сангийн байгууллагын хэмжээнд 1,383.9 мянга, Орон нутгийн тусгай сангийн байгууллагын хэмжээнд 6,029.5 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэмжээнд 108,847.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 100,265.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

### 2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

#### 2.8.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

ЗДТГ нь үр дүнгийн тайланд 7,776.2 мянган төгрөгөөр бараа материалын зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан, Сум хөгжүүлэх сан орлогын төлөвлөгөөг 9.8%-иар буюу 6,029.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн тайланд зардлыг бодит гарсан зардлаар тайлагнах, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Тайлант онд ЗДТГ нь 7,847.5 мянган төгрөгийн өглөг, 169.9 мянган төгрөгийн авлагатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг, авлагын тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө баталгаажуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 2.8.1.3 Балансын данстай холбоотой асуудал

3-р сургууль, цэцэрлэг нь 65,040.4 мянган төгрөгийн бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон акт үйлддэггүй, жилийн эцсийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.21 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хагас бүтэн жилээр хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийж, тооцоо бодсон акт үйлдэж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 2.8.1.4 Зардлын данстай холбоотой асуудал

3-р сургууль нь 36,489.2 мянган төгрөгийн үдийн цай нийлүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтын шийдвэр, үдийн цайг орлогоор бүртгэдэг, үдийн цайнд хяналт тавьсан баримт, хоолны цэс зэргийг гүйцэтгэлд хавсаргаагүй, 9,795.0 мянган төгрөгийн усны зарцуулалтад тавих хяналт сул / эхний эцсийн заалтыг баталгаажуулдаггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 7 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

#### Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой		Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа		Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа		Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
	Эрүүл мэндийн төв хандиваар хүлээн авсан тоног төхөөрөмжийг орлогод	49,990.2						49,990.2	



авахдаа Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлсэн

Соёлын төв дахин үнэлгээгээр газар орлогод авахдаа үнэ төлбөргүй орлого дансыг нэмэгдүүлсэн

9,026.0

9,026.0

3-р сургуулийн үнэ төлбөргүй орлогыг хувьцааны ногдол ашиг дансаар нэгтгэсэн

1,968.0

1,968.0

Худалдан авсан нийт үндсэн хөрөнгийг бусад дансанд нэгтгэсэн

1,792.0

1,792.0

Сум хөгжүүлэх сангийн тайланд зээлийн хүүгийн орлогыг давхар бүртгэсэн

12,353.3

12,353.3

Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоог дутуу хийсэн, бараа үйлчилгээний бусад зардлыг дутуу тайлагнасан

888.7

888.7

Дүн

76,018.2

76,018.2

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	32,034.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	795.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	32,829.4	

## 2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.8.2.1. Балансын данстай холбоотой асуудал

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бэлтгэсэн орон нутаг судлах танхимын тохижилтонд худалдан авсан 605.0 мянган төгрөгийн сандал, баяр наадмын зардлаас бэлтгэсэн 190.0 мянган төгрөгийн гэрийн бүслүүр, хаяавч, бүрээс зэргийг орлогод аваагүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бэлтгэсэн хөрөнгө, материалыг бүртгэлд тусгах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд хамрагдаж буй Байгаль хамгаалах сан болон Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй, аудитлагдаагүй тайлан нэгтгэгдсэн тул тус 2 сангийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт оруулах нь зүйтэй гэж үзлээ.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

"Шивээговь сумын Засаг дарга"-д өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2,210,342.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
				Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,196,442.6	2,101,659.6	95.7%	94,782.9
1.1	Урсгал зардал	1,997,336.8	1,965,179.8	98.4%	32,156.9

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.2	Хөрөнгийн зардал	0.0	0.0		
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0.0	0.0		
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,196,442.6	2,166,654.8	98.6%	29,787.7
2.1	Улсын төсвөөс санхүүжих	1,725,378.1	1,718,968.9	99.6%	6,409.2
2.2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	395,322.9	389,964.3	98.6%	5,358.6
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	16,294.6	4,848.6	29.7%	11,445.9
2.4	Бусад эх үүсвэр	59,447.0	52,873.0	88.9%	6,573.9

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,101,659.6 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь цалин болон шимтгэлийн зардлаас 6,295.7 мянга, тогтмол зардлаас 2,986.8 мянга, хангамжийн бараа материалын зардлаас 32.6 мянга, эд хогшил урсгал засварын зардлаас 273.2 мянга, дотоод албан томилолтын зардлаас 45.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 381.5 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 19,779.5 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 2,362.4 мянга, хөрөнгийн зардал 1,198.2 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэж төлөгдөх зээлийн төлөвлөгөө 61,428.0 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тайланд онд нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 1,618,790.4 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 395,322.9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилт 106,550.5 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 81,171.1 мянга, сумын татварын орлого гүйцэтгэлээр 70,231.3 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого гүйцэтгэлээр 1,228.2 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1,591.2 мянга, бусад орлого 1,546.6 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 45,805.8 мянга, аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 337,444.4 мянга, орон нутгийн төсвийн байгууллагын төвлөрүүлсэн орлого 5,358.6 мянга, нийт 2,665,041.2 мянган төгрөгийн орлогыг тайлагнажээ.

Тайланд онд нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 1,618,790.4 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 395,322.9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилт 106,550.5 мянга, сумын татварын орлого гүйцэтгэлээр 70,231.3 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого гүйцэтгэлээр 1,228.2 мянга, туслах үйл ажиллагааны орлого 3,620.4 мянга, бусад орлого 5,850.0 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 45,805.8 мянга, аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 337,444.4 мянга, орон нутгийн төсвийн байгууллагын төвлөрүүлсэн орлого 5,358.6 мянга, сум хөгжүүлэх сангийн зээлээс эргэж төлөгдөх 52,873.0 мянга, нийт 2,643,075.6 мянган төгрөгийн орлогыг тайлагнажээ.

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд 139,445.7 мянган төгрөг байна.

2018 онд 187,760.0 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдэлтэй байснаас нийт 57,745.3 мянган төгрөгөөр хасагдаж, 130,014.7 мянган төгрөгийн авлагыг үлдэгдлээр тайлагнасан ба соёлын төв, ЗДТГ-ын татварын авлага 165.2 мянга, мал хамгаалах сан, сум хөгжүүлэх сан, ЗДТГ-ын хувь хүмүүсээс авах авлага 121,694.4 мянга, эрүүл

мэндийн төвийн байгууллагаас авах авлага 7,800.0 мянга, үйлдвэрчний эвлэлийн авлага 355.1 мянган төгрөг байна. Авлага өмнөх оноос 30.7 хувиар буурсан байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Тайланд хугацаанд 135,191.9 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр 238,352.1 мянга, хандиваар 21,139.2 мянга, шилжүүлэн авсан 1,884.9 мянга, бусад 392.4 мянга, нийт 261,768.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 243,203.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,491.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хасч, оны эцэст 151,265.1 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

2018 онд 7,552,060.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байснаас худалдан авсан үндсэн хөрөнгө 1,950.0 мянга, хандиваар 60,031.9 мянга, хөрөнгийн дахин үнэлгээгээр барилга 23,921.1 мянга, газар 137,394 мянга, шилжүүлэн авсан 481,565.8 мянга, нийт 704,862.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 9,298.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасч, 483,450.8 мянган төгрөгийг шилжүүлж, дахин үнэлгээний хорогдол 1,513,244.9 мянга, нийт 2,005,994.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хасч, 6,250,929.5 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

2018 онд 8,089.2 мянган төгрөгийн өглөгийн эхний үлдэгдэлтэй байснаас нийт 11,009.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 19,098.5 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан ба соёлын төв, 3-р сургууль, 3-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн шимтгэлийн өглөг 1,996.8 мянга, Эрүүл мэндийн төвийн татварын өглөг 2,422.8 мянга, ЗДТГ-ын цэвэр, бохир усны өглөг 7,689.8 мянга, ОНХС-ын барьцаа, ЗДТГ-ын байгууллагад төлөх өглөг 6,840.5 мянга, хувь хүмүүст төлөх өглөг 148.6 мянган төгрөг байна.

Өглөгийн үлдэгдэл өмнөх оноос 57.6 хувиар өссөн байна. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Засгийн газрын оруулсан капитал данс газрын дахин үнэлгээтэй холбоотой 137,394.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар 45,805.8 мянган төгрөгийн орлого авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл:

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Татварын орлого				
2	Сум хөгжүүлэх сан	57,878.5	70,231.3	121.3	12,352.8
3	Мал хамгаалах сан	61,428.0	55,398.5	90.2	6,029.5
4	Соёлын төв	1,700.0	1,095.0	64.4	605.0
		1,838.7	1,228.2	66.8	610.5

Тайлант онд сумын татварын орлогын төлөвлөгөө 57,878.5 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 70,231.3 мянга буюу 21.3 хувиар давуулан биелсэн нь хадгаламжийн хүүгийн орлого болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөөгүйтэй холбоотой юм.

Сум хөгжүүлэх сан 6,029.5 мянга буюу 9.8 хувь, мал хамгаалах сан 605.0 мянга буюу 35.6 хувь, соёлын төв 610.5 мянга буюу 33.2 хувиар тус тус орлогын төлөвлөгөө тасарч, орлого биелээгүй байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

"Шивээговь сумын Засаг дарга" нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 147 мэдээллийн 2 нь хугацаа болоогүй ба нийт оруулсан мэдээллийн 15 буюу 10.3% нь хугацаа хоцорч оруулсан мэдээлэл байна. Цаашид шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллах нь зүйтэй.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 36.2 хувь буюу 100,265.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.4 хувь буюу 1,077.7 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 0.4 хувь буюу 795.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 63.1 хувь буюу 174,792.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт				Залруулга			
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	5	32,829.4	7	76,018.2	12	108,847.6	7	76,018.2
2	ТШЗ	23	136,422.0	13	24,246.9	36	160,668.9	13	24,246.9
3	ЗГТС	2	795.0	2	588.9	4	1,383.9		
4	ОНТС	1	6,029.5			1	6,029.5		
	Дүн	31	176,075.9	22	100,564.0	53	276,929.9	20	100,265.1

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	5	32,829.4					5	32,829.4				
2	ТШЗ	23	136,422.0	4	1,077.7			27	135,344.3				
3	ЗГТС	4	1,383.9			2	795.0	6	588.9				
4	ОНТС	1	6,029.5					1	6,029.5				
	Дүн	33	176,664.8	4	1,077.7	2	795.0	39	174,792.1				

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Дүн
1	ТШЗ	3	2			5
	Дүн	3	2			5

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Шивээговь сумын Засаг дарга"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 07 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

### 3.2 ОРЛОГЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгохоор тогтоолд тусгасан боловч уг санхүүжилт бүрэн олгогдоогүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

#### Хариуцах ажилтан

Засаг дарга С.Ягаанцэцэг  
Нягтлан бодогч У.Чулуунцэцэг

#### Эрсдэл

Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэл үүсэх

#### Зөвлөмж

Тогтоолд тусгасан дүнгээр тусгай зориулалтын шилжүүлгийг бүрэн олгох

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн



### 3.4 НЭГТГЭСЭН ТАЙЛАНГ БЭЛТГЭН ГАРГАХ ТАЛААР

#### Илрүүлэлт

Санхүүгийн нэгтгэсэн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, тайланг хянаж хүлээн аваагүй, тоон мэдээллүүд зөрүүтэй, тайлангийн уялдаа холбоог хангаагүй нэгтгэсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 341 дүгээр тушаалыг зөрчсөн байна.

#### Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлэх, тоон мэдээллүүдийг хянаж хүлээн авах, тайлангийн уялдаа холбоог хангах

#### Хариуцах ажилтан

Засаг дарга С.Ягаанцэцэг  
Нягтлан бодогч У.Чулуунцэцэг

#### Эрсдэл

Холбогдох хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

### 3.3 ОРЛОГЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Мал хамгаалах сан, байгаль хамгаалах санг хааж нэгтгээгүй, аймгийн СТСХ-ээс 2016 онд хүргүүлсэн чиглэлийг баримталж ажиллаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 147 дугаар тогтоолын 2 дахь заалтыг зөрчсөн байна.

#### Хариуцах ажилтан

Засаг дарга С.Ягаанцэцэг  
Нягтлан бодогч У.Чулуунцэцэг

#### Эрсдэл

Холбогдох хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй

#### Зөвлөмж

Мал хамгаалах, байгаль хамгаалах сангийн чиг үүрэг нь Орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгтэй давхцаж байгаа тул 2 санг нэгтгэх замаар татан буулгах

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

**"Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"-гийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

№	Сорилын лавлагаа (дансны хэсэг)	Асуудал	Илрүүлсэн зөрчлийн дүн /төг/	Асуудал гарган тавьсан аудитор	Базанст нөлөөлсөн эсэх	Асуудлыг шийдвэрлэх уулаагт	Зөвшөөрсөн арга хэмжээг /асуудлыг шийдвэрлэхийн дараа/
1	Үндсэн хөрөнгө	Шивээговь сумын Эрүүл мэндийн төв хандиваар хүлээн авсан тосгог төхөөрөмжийг орлогод авахдаа "Засгийн газрын сан" дансыг нэмэгдүүлсэн	40,990,150.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
2	Үндсэн хөрөнгө	Шивээговь сумын Соёлын төв дахин үнэлгээгээр газар орлогод авахдаа "үнэ төлбөргүй орлого" дансыг нэмэгдүүлсэн	9,026,000.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
3	Орлого	3-р сургуулийн үнэ төлбөргүй орлогыг хувицааны ногдол ашиг дансаар нэгтгэсэн	1,968,000.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
4	Үндсэн хөрөнгө	Худалдан авсан нийт үндсэн хөрөнгийг бусад дансанд нэгтгэсэн	1,792,000.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
5	Орлого	Сум хөгжүүлэх сангийн дансанд зээлийн хүүгийн орлогыг нэгтгэсэн	12,353,315.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
6	Зардал	Төсвийн гүйцэтгэлийн тайлан төвлөрүүлэх шилжүүлгийн тооцоогоор дууу хийсэн	618,735.31	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
7	Зардал	Төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг дууу тайлагнасан	270,000.0	Б.Аюулсуа	Нөлөөтэй	Загруулга	Загруулсан
8	Хөрөнгө	Орон нулаг судлах танхимын тооцоонд худалдан авсан сандлыг бүртгээгүй	605,000.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Албан шаардлага	Албан шаардлага
9	Бараа материал	Баар наадмын зарлаас бэлтгэсэн гэрийн бүслүүр, хаванч, бүрээс зэргийг орлогод аваагүй, шууд зардалаар тайлагнасан.	190,000.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Албан шаардлага	Албан шаардлага
10	Зардал	ОНХС-ийн тайланд бэлтгэн нийлүүлэгчээс суулгасан ХХОАТ-ыг татварт шилжүүлээгүй	474,500.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Зөвлөмж	Зөвлөмж
11	Зардал	Баар наадмын зардалас ариг согнууруулах ундаа бэлтгэсэн	114,500.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Зөвлөмж	Зөвлөмж
12	Орлого	Сум хөгжүүлэх сан, мал хамгаалах сан, соёлын төвийн орлогын төлөвлөгөө биелээгүй	7,245,035.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Зөвлөмж	Зөвлөмж
13	Орлого	Тусгай эрмүүлэмийн шилжүүлгийн санхүүжилт олгохоор тогтоолд тусгасан боловч уг санхүүжилт бүрэн олгогдосгүй	13,900,000.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Зөвлөмж	Зөвлөмж
14	Орлого	Мал хамгаалах сан, байгаль хамгаалах санг хааж нэгтгээгүй, аймгийн СТСХ-ээс 2016 онд хүрүүлсэн чөлөөлийг баримталж авчлаагүй	10,300,319.0	Б.Аюулсуа	Нөлөөгүй	Зөвлөмж	Зөвлөмж
<b>Нийт дүн</b>			<b>108,847,554.3</b>				

Балтгасж: Аудитор *Аюулсуа* Б.Аюулсуа  
 Зөвшөөрсөн: Дарга *Утга* С.Яаанцэцэг  
 Зөвшөөрсөн: Нэгтгэл Бодогч *Утга* У.Чулуунчимэг  
 Хянасан: Аудитын менежер *Утга*

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

2019.03.25

№	Алдаа зөрчлийн утга	Зөрчлийн дүн	Шийдвэрлэсэн байдал /мөнгөн төгрөгөөр/						Санал дүгнэлтийн хэлбэр							
			Залруулсан	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Зөрчлийн	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалсан	Түүвэр	Итгэмжлэл	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн							
1	Шивээговь сумын ИТХ	1,968.7	1,034.5					3	934.2	1						
2	Шивээговь сумын ЗДТГ	17,153.4	7,776.2					3	9,377.2	1						
3	Шивээговь сумын ОНХС	1,383.9				2	795.0	2	588.9							1
4	3-р цэцэрлэг	14,977.1	214.9	2	646.1	3	14,116.1	3	105,440.7							
5	3-р сургууль	114,043.5	8,171.2	2	431.6	7	105,440.7	7	105,440.7							
6	Шивээговь сумын соёлын төв	-	-	-	-	-	-	-	-							1
7	Сум хөгжүүлэх сан	6,029.5				1	6,029.5	1	6,029.5							1
8	Байгаль хамгаалах сан	-	-	-	-	-	-	-	-							
9	Мал хамгаалах сан	-	-	-	-	-	-	-	-							
10	Эрүүл мэндийн төв	12,526.2	7,050.1					3	5,476.1	1						
11	Төрийн сан	108,847.5	76,018.2					1	32,829.3	1						
	<b>НИЙТ АЛДАА ЗӨРЧЛИЙН ДҮН</b>	<b>276,929.8</b>	<b>100,265.1</b>	<b>4</b>	<b>1,077.7</b>	<b>2</b>	<b>795.0</b>	<b>23</b>	<b>174,792.0</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Зөрчлийн нэгтгэл гаргасан аудитор: Б.Аюуяа ( )